

САНХҮҮГИЙН БУС ЗАХИРЛУУДАД ЗОРИУЛСАН САНХҮҮГИЙН СУРГАЛТ

Энэхүү хоёр өдрийн эрчимжүүлсэн сургалт нь санхүүгийн шинжилгээний хэрэгсэл, арга техникийг бизнесийн шийдвэр гаргалтад ашиглахад суралцахыг хүссэн санхүүгийн бус мэргэжилтэй удирдах ажилтнуудад тусгайлан зориулагдсан.

ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА:

Хоёр өдрийн сургалтаар бид орлого, зарлага, төсөв, санхүүгийн тайлангийн ойлголтыг сайжруулж удирдлагын шийдвэр байгууллагын санхүүгийн байдалд хэрхэн нөлөөлдөг болохыг танилцуулна. Та сургалтанд компанийн мөнгөн урсгал, ашигт ажиллагааны түвшинд нөлөөлөх хүчин зүйлс, санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн гол нэр томъёо, зарчмуудыг суралцах болно.

ОРОЛЦОГСОД:

Санхүүгийн мэдлэг, чадвараа дээшлүүлэхийг хүссэн компанийн ТУЗ-ийн гишүүд, захирлууд, удирдах ажилтнууд, голлох шийдвэр гаргагчид, санхүүгийн бус менежерүүд, хянан шалгагчид, бизнесийн эзэд, санхүүгийн бус албан тушаал хашиж буй мэргэжилтнүүд хамрагдана.

СУРГАЛТАНД ХАМРАГДСАНААР ТА:

- ❖ Мөнгөн урсгал, ашигт ажиллагаанд нөлөөлдөг хүчин зүйлсийг мэдэх
- ❖ Санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн гол нэр томъёо, зарчмуудтай танилцах
- ❖ Санхүүгийн тайлангийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа холбоог ойлгож, тайлбарлах
- ❖ Санхүүгийн тайланг ашиглан компанийн санхүүгийн үйл ажиллагааг шинжлэх
- ❖ Бизнесийн зорилго, зорилтыг хангахад чиглэсэн төсөв боловсруулах

СУРГАЛТЫН БҮТЭЦ:

Сургалт 2 өдөр үргэлжилнэ. Сургалт интерактив байдлаар оролцогчдын асуулт хариулт, кейс сургалт, харилцан бие биенийхээ туршлагаас суралцах боломжийг дэмжих аргаар явагдана.

БАГШ НАР:

Бүх багш нар нь олон улсын түвшинд бэлтгэгдсэн Монголын цорын ганц байгууллага болох Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн сургагч багш нар хөтлөн явуулна.

СУРГАЛТЫН ТӨЛБӨР: 400 000₮ (CGDC-ийн гишүүн байгууллагууд 20% хөнгөлөлттэй)

Компани, аж ахуйн нэгжүүд өөрийн байгууллага дээрээ сургалт авах боломжтой (Төлбөрийн хөнгөлөлттэй байж болно). Төгсөгчдөд гэрчилгээ олгоно. Сургалтын төлбөрт холбогдох бүх зардлууд багтсан болно. Сурах бичиг, материал, танилцуулгаар бүрэн хангана.

ХОЛБОО БАРИХ:

Утас: 7000 8084, 991051111, 88978179

Цахим шуудан: info@cgdc.org.mn



ХӨТӨЛБӨР

Эхний өдөр

I. Санхүүгийн нэр томъёоны төөрөгдлөө арилгаж, санхүүгийн асуудлаар оюунлаг ярьж сурах (10:00 а.м. – 11:20 а.м.)

- Тогтмол ба хувьсах зардал, ашиг, алдагдал гэх мэт бүртгэл ба санхүүгийн нийтлэг нэр томъёоны цаад учрыг тайлах
- Төслөө хурдан батлуулахад шаардлагатай саналаа танилцуулах чадвар, зөвлөмжийн чанараа сайжруулах
- Бүртгэлийн үндсэн тайлан тэнцэл, болон хэрэглээний аргад суралцах
- Бизнесийн хэлээр санхүүгийн тайлан, мэдээллийг уншиж, бусадтай чөлөөтэй ярилцдаг болох
- Санхүүгийн мэдээллийг хэн ашигладаг вэ?
- Санхүүгийн тайлагналын журмууд, хэн энэ журмыг гаргадаг вэ?
- Бизнес эрхлэнэ гэдэг юу гэсэн үг вэ?
- Мөнгөн урсгалд нөлөөлөгч хүчин зүйлс

Цайны цаг (11:20 а.м. – 11:30 а.м.)

II. Таны мэдэх ёстой чухал ойлголтууд (11:30 а.м. – 12:50 р.м.)

- Эргэлтийн өр төлбөр, эргэлтийн хөрөнгө, өөрийн хөрөнгө хоорондын ялгаа
- Эргэлтийн хөрөнгийн бүтэц, уг бүтэц нь өдөр тутмын үйл ажиллагаанд хэр чухал болох
- Хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцох энгийн арга
- “Гүүдвилл” Бүх компаниуд үүнийг тэнцэлдээ тусгах ёстой юу?
- Гүйцэтгэлийг хэмжих санхүүгийн голлох харьцаанууд
- Биет ба бусад хөрөнгүүд, тэнцэл дээр байгаа тоо юуг нууцладаг вэ?
- Тайлан тэнцэл болон ашиг орлогын тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүд
- Гүйлгээг хэрхэн орлогын тайлан, тэнцэлд тусгах ёстой вэ?
- Мөнгөн урсгалын тайлан нь ашиг орлогын тайлан болон тайлан тэнцлийн уялдаа холбоо
- Санхүүгийн тайлангийн гол харьцаанууд бидэнд юу хэлдэг вэ?
- Төсвийн төрөл хэлбэрүүд, тэдгээрийн санхүүгийн тайлантай уялдах харилцаа

Өдрийн хоол (12:50 р.м. – 14:00 р.м.)

III. Мэдэх шаардлагатай бүртгэлийн үндсүүд (14:00 р.м. – 16:00 р.м.)

- Бүртгэлийн мөчлөгүүд хэрхэн ажилладаг болох

- Хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлагыг хэрхэн бүртгэдэг вэ
- Мөнгөн ба аккрузал суурьт бүртгэлийн ялгаа
- Удирдах ажилтан бүрийн ойлгох ёстой олон улсын бүртгэлийн стандартын зарчмууд
- Байгууллагын төсвийг боловсруулахад дебет, кредитийг тайлбарлах
- Төсвийг гүйцэтгэлтэй харьцуулан тайлбарлах
- Өөрчлөлтийг төсвийн тооцоололд тусгах

Хоёр дахь өдөр

IV. Санхүүгийн тайланг зөв, соргоогоор тайлбарлах (09:00 a.m. – 10:20 a.m.)

- Тэнцэл, орлогын тайлан, мөнгөн урсгалын тайланг хэрхэн уншиж тайлбарлах вэ
- Ашиг, алдагдлын тайланг хэрхэн шинжилж, борлуулсан бүтээгдэхүүний зардал, орлогыг хэрхэн олж, ашигт ажиллагааны талаар хэлж чаддаг болох
- Санхүүгийн тайлан бэлтгэх үндсэн үе шатууд
- Урт хугацаатай хөрөнгийн төрөл ба үнэлгээг тодорхойлоход элэгдэл, хорогдолын гүйцэтгэх үүрэг
- Санхүүгийн тайланг хэрхэн тайлж, хамгийн үнэ цэнэтэй мэдээлэл рүү анхаарлыг хэрхэн хандуулах вэ

Цайны цаг

(10:20 a.m. – 10:30 a.m.)

V. Шийдвэр гаргалтаа санхүүгийн арга техникийн тусламжтайгаар хурцлах

- Хугарлын цэгийн шинжилгээ, таамаглал зэрэг шинжилгээний хэрэгслүүдийг ашиглан мэдээлэл сайтай, оновчтой шийдвэр гаргах
- Санхүүгийн харьцаанууд нь ирээдүйн аюулыг урьдчилж харах үзүүлэлт болж байдаг
- Санхүүгийн харьцаануудыг ашиглан компанийн ашигт ажиллагаа, хөрвөх чадвар, хөшүүргийг үнэлэж сурах
- Төслийн эрсдлийн түвшинг хэрхэн үнэлэх вэ
- Санхүүгийн хүндрэлтэй тулгарах үед тавих ёстой чухал асуултууд
- Хяналтандаа байлгах боломжгүй ч зайлшгүй ойлгох ёстой санхүүгийн чухал асуудлууд
- Төсөв боловсруулахад ямар тоонд тулгуурлах ёстой вэ?
- Хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцох

Өдрийн хоол

(11:50 p.m. – 13:00 p.m.)

VI. Орлого, өсөлтөө төлөвлөх

(13:00 p.m. – 15:00 p.m.)

- Мөнгөн урсгалыг хэрхэн таамаглах, түүнийг ашиглан ажиллагсдын зардал, худалдан авалтын өртөг өсч буй үед зардлаа бууруулах
- Хямралын үе дэх компанийн санхүүгийн удирдлага
- Мөнгөн урсгалын хүндэрлийг хэт оройтохоос нь өмнө хэрхэн урьдчилан таних вэ